


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

“XIX.2. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн талаар Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дээр дурдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгийг хуваарийн дагуу төсвийн жилд багтаан санхүүжүүлэх, төсвийн гүйцэтгэлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайдын үүрэг гүйцэтгэгч П.Ганхүү, Барилга, хот байгуулалтын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Мөнхбаяр, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Ганбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР